



2014.. оны 06 сарын 16 өдөр

№ 01

Улаанбаатар хот

НЭЭЛТТЭЙ ЗАСГИЙН ТҮНШЛЭЛИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ШИЙДВЭР № 01

Дарга: 3ГХЭГ-ын дарга Ч.Сайханбилэг

Гишүүд: 3ГХЭГ-ын Дэд дарга Ч.Сайнбилэг
ГХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Г.Цогтсайханыг төлөөлж
С.Сүхболд
ХЗЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Баярцэцэг
СЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Х.Ганцогт
ЭЗХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Б.Шинэбаатар
Иргэний нийгмийн байгууллагуудын Зөвлөлийг төлөөлж
MYXAYT-ийн дарга С.Дэмбэрэл нар оролцов.

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

- “Нээлттэй засгийн түншлэлийн үйл ажиллагааны үндэсний төлөвлөгөө”-г (2014-2016 он) батлах тухай
- “Нээлттэй засгийн түншлэлийн Удирдах зөвлөлийн дүрэм”-ийг батлах тухай

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

- “Нээлттэй засгийн түншлэлийн үйл ажиллагааны үндэсний төлөвлөгөө”-г Хавсралт 1 ёсоор баталсугай.
- “Нээлттэй засгийн түншлэлийн Удирдах зөвлөлийн дүрэм”-ийг Хавсралт 2 ёсоор баталсугай.

Дарга

Ч.САЙХАНБИЛЭГ

Гишүүд:

Ч.САЙНБИЛЭГ

Г.ЦОГТСАЙХАН

Ж.БАЯРЦЭЦЭГ

Х.ГАНЦОГТ

Б.ШИНЭБААТАР

С.ДЭМБЭРЭЛ

Монгол Улсын Засгийн газар

**МОНГОЛ УЛСЫН НЭЭЛТТЭЙ ЗАСГИЙН ТҮНШЛЭЛИЙН
ҮНДЭСНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

2014-2015 он

Улаанбаатар хот

АГУУЛГА

| | |
|---|----------|
| Нэг. Оршил..... | 1 |
| Хоёр. Туршлага ба тулгамдсан асуудал..... | 1 |
| 2.1. Ил тод, нээлттэй байдлын туршлага..... | 1 |
| 2.2. Тулгамдсан асуудал..... | 2 |
| Гурав. Нээлттэй Засгийн түншлэлийн үйл ажиллагааны зарчим ба хүрээ.... | 3 |
| 3.1. Үйл ажиллагааны зарчим..... | 3 |
| 3.2. Үйл ажиллагааны хүрээ..... | 4 |
| 3.3. Үйл ажиллагааны үндэсний төлөвлөгөөг боловсруулсан үйл явцын танилцуулга..... | 4 |
| 3.4. Нээлттэй Засгийн түншлэлийн үйл ажиллагааны үндэсний төлөвлөгөөг хэрэгжүүлэх бүтэц, зохион байгуулалт..... | 5 |
| Дөрөв. Үйл ажиллагааны үндэсний төлөвлөгөө..... | 5 |
| Хавсралт..... | 6 |

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

| | |
|-----------|---|
| АМГ | Ашигт малтмалын газар |
| АТГ | Авлигатай тэмцэх газар |
| БОНХЯ | Байгаль орчин, ногоон хөгжлийн яам |
| ГТГ | Газрын тосны газар |
| ГХЯ | Гадаад хэргийн яам |
| ЗГ | Засгийн газар |
| ЗГХЭГ | Засгийн газрын Хэрэг эрхлэх газар |
| ЗДТГ | Засаг даргын Тамгын газар |
| ИНБ | Иргэний нийгмийн байгууллага |
| ИТХ | Иргэдийн төлөөлөгчдийн хурал |
| МТШХХГ | Мэдээлэл технологи, шуудан, харилцаа холбооны газар |
| СЯ | Сангийн яам |
| УИХ | Улсын Их Хурал |
| УИХ-ын ТГ | Улсын Их Хурлын Тамгын газар |
| УУЯ | Уул уурхайн яам |
| YAX | Үндэсний Аудитын хороо |
| YCХ | Үндэсний Статистикийн хороо |
| ТАЗ | Төрийн албаны зөвлөл |
| ХААГ | Худалдан авах ажиллагааны газар |
| ХЗЯ | Хууль зүйн яам |
| ХЭҮК | Хүний эрхийн үндэсний комисс |
| ЭЗХЯ | Эдийн засгийн хөгжлийн яам |

Нэг. Оршил

Монгол Улсын Засгийн газар үйл ажиллагаандаа ил тод, нээлттэй, иргэний оролцоотой, шударга, хариуцлагатай байх Нээлттэй Засгийн түншлэлийн зарчмуудыг хүлээн зөвшөөрч, түүнд нэгдэн орж, тууштай хэрэгжүүлэхээр зорьж байна.

Нээлттэй Засгийн түншлэлийн үйл ажиллагааны үндэсний төлөвлөгөөг төр, иргэний нийгмийн байгууллагын өргөн оролцоотой боловсруулж, үйл ажиллагааны үр дүнгээ нээлттэй тайлагнаж, хяналттай, хариуцлагатайгаар хамтран хэрэгжүүлнэ.

Нээлттэй Засгийн түншлэлийн үйл ажиллагааг бүх салбарт хэрэгжүүлэхдээ юуны өмнө мэдээлэл, технологийн дэвшилийг нэвтрүүлж, сайн туршлагыг түгээн дэлгэрүүлж, олон улсын шилдэг туршлагаас харилцан суралцаж ажиллана.

Энэ зорилгоор өөрийн орны ил тод, нээлттэй байдлын ололт, сургамж, тулгамдсан асуудлыг тодорхойлж, Нээлттэй Засгийн түншлэлийн үйл ажиллагааны үндэсний төлөвлөгөөг олон нийтээр хэлэлциүүлэн боловсруулж, хэрэгжүүлэхээр танилцуулж байна.

Хоёр. Туршлага ба тулгамдсан асуудал

2.1. Ил тод, нээлттэй байдлын туршлага

Монгол Улс Авлигын эсрэг Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенцэд 2005 онд нэгдэн орж, Авлигын эсрэг хуулийг 2006 онд, Нийтийн албанад нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг 2012 онд тус тус батлан мөрдүүлсэн нь нийтийн албыг авлигаас ангид, хариуцлагатай, ил тод болгох нэг чухал нөхцөл боллоо. Түүнчлэн Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийг 2011 онд баталж, төрийн байгууллагын хуулиар хориглосноос бусад бүх мэдээлэл ил тод болох эрх зүйн орчинг бүрдүүлсэн юм.

Монгол Улс Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын олон улсын санаачилгад нэгдэн орж, уул уурхай, газрын тосны салбараас улсын болон орон нутгийн төсөвт төлдөг татвар, төлбөрийг 2006 оноос эхлэн ил тод болгоод байна. Төсвийн ил тод байдлыг хангах “Шилэн дансны тогтолцоо”-нд шилжих тухай Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг гарч¹, төсвийн бүх шатны байгууллага хэрэгжүүлэх үүрэг хүлээгээд байна.

¹ Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2013 оны 06-р сарын 12-ны өдрийн 88 дугаар зарлиг.

Бодлого боловсруулах, шийдвэр гаргахад иргэдийн оролцоог хангах зорилгоор Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар 2009 онд “Иргэний танхим” анх байгуулагдаж байсан бол эдүгээ аймаг, дүүрэг, сумдад ажилладаг боллоо. “Шууд ардчилал, иргэдийн оролцоогоор дамжуулан төвлөрлийг сааруулах үндэсний дунд болон урт хугацааны бодлогын баримт бичиг”² батлагдаж шууд ардчиллын зарчмууд хэрэгжиж эхэллээ.

Засгийн газар “11-11” төв байгуулж иргэдээ сонсох боломжийг бүрдүүлэн утсан болон шуудан холбоо, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дамжуулан тэдний санал хүсэлт, тулгамдсан асуудлыг шууд хүлээн авч, шийдвэрлэдэг болсон. Мөн төрийн үйлчилгээг хүнд сурталгүй, хурдан шуурхай, хүртээмжтэй хүргэх зорилгоор “Төрийн үйлчилгээний цахим машин” ажиллуулж эхлээд байгаа ба цаашид бүх сум, дүүрэг, хороонд нэвтрүүлэхээр зорьж байна.

Улсын Их Хурлаас Өргөдлийн байнгын хороог байгуулан, иргэдийн өргөдөл, гомдлыг судалж, барагдуулах арга хэмжээ авч байгаагийн зэрэгцээ нээлттэй сонсгол хийх эрх зүйн орчныг бүрдүүлсэн байна.

Монгол Улсын Ерөнхий сайд “Бүтээн байгуулалтын цаг”, “Ерөнхий сайдын 30 минут”, “Хариуцлага, хяналт, хэрэгжилт”, “Цахим хурал”, “Өглөөний шинэ санаа” сэдэвт Засгийн газрын бодлого, үйл ажиллагааны талаарх төрөлжсөн мэдээллийг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр долоо хоног, сар тутам тогтсон хугацаанд, нээлттэй, ил тод мэдээлж, ажлаа тайлагнаж байгаа нь нээлттэй засгийн сайн туршлага болж байна.

Төрийн үйлчилгээг иргэнд ойртуулах, шат дамжлагыг багасгах, шуурхай болгох зорилго бүхий “Нэг цонхны үйлчилгээ”-г аймаг, дүүргүүдэд хэрэгжүүлсэн нь олны талархлыг хүлээсэн сайн туршлага болсон ба сум, хорооны түвшинд нэвтрүүлэхээр ажиллаж байна.

Төрийн үйлчилгээний стандарт тогтоож, үйлчилгээний цагийн хуваарь, үйлчилгээний хэлбэр, нөхцөл, төлбөр болон бусад мэдээллийг цахимжуулан иргэдэд нээлттэй болгосон байгууллагууд нэмэгдсээр байна.

Шүүхийн тогтолцоог шинэчлэх, бие даасан, хараат бус байдлыг хангах, хэрэг маргааныг шударгаар шийдвэрлэх тогтолцоог бий болгох, шүүхийн ил тод байдлыг нэмэгдүүлэх зорилгоор шүүхийн багц хуулийг 2012 онд баталж, шүүх эрх мэдлийн шинэтгэлийг гүнзгийрүүлэх, хууль зүйн салбарыг шинэчлэх хүрээнд зайлшгүй шаардлагатай Хуульчийн эрх зүйн байдлын тухай, Тахарын албаны тухай, Гэрч, хохирогчийг хамгаалах тухай, Цагдаагийн албаны тухай, Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хуулиудыг Улсын Их Хурал баталлаа. Эдгээр хуулийн төслүүд иргэд, холбогдох мэргэжилтнүүдийн өргөн оролцоотойгоор боловсруулагдсан бөгөөд хууль, шүүхийн байгууллагын нээлттэй, ил тод, хариуцлагатай байдлыг нэмэгдүүлэх эрх зүйн зохицуулалт болж байна.

² Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2012 оны 09-р сарын 19-ны өдрийн 176 дугаар зарлиг.

2.2. Тулгамдсан асуудал

Төрийн ил тод, нээлттэй байдал, иргэдийн оролцоог хангаж, үйлчилгээг чанар, хүртээмжтэй хүргэж, шударга ёсыг бэхжүүлэхэд дараах асуудал тулгамдсан хэвээр байна:

2.2.1. Ил тод байдал, иргэдийн оролцоог хангах чиглэлээр:

2.2.1.1. мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль хэрэгжиж эхэлсэн ч хэт ерөнхий, ихэнхдээ бодлогын шинжтэй үйл ажиллагаа, баримт бичгүүдийг ил тод болгохоор заасан нь хангатгүй байна;

2.2.1.2. ил тод байдлын стандартгүй, ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт хэт ерөнхий байгаа тул ил тод байдал бодитойгоор хангагдаж байгааг үнэлэх боломжгүй байна;

2.2.1.3. иргэд төрийн үйл ажиллагааг хянах, шийдвэр гаргахад оролцох, шийдвэрийн үндэслэлтэй танилцах боломж хязгаарлагдмал, зарим тохиолдолд хаалттай хэвээр байна. Бодлого боловсруулах явцад иргэдийн оролцоог хангах сайн туршлага бий болж байгаа ч олон нийтийн оролцоогүй төрийн бодлого, шийдвэрүүд гарсан хэвээр байна.

2.2.2. Төрийн үйлчилгээг сайжруулах чиглэлээр:

2.2.2.1. төрийн байгууллагын үйлчилгээний стандарт нь үйлчлүүлэгчдэд бус төрийн байгууллагад зориулсан, үйлчилгээний тодорхойлолт, зорилго, хариуцлага, стандартын хэрэгжилтийг үнэлэхтэй холбоотой асуудлууд орхигдсон байна;

2.2.2.2. мэдээллийн технологийн дэд бүтэц, зохион байгуулалт, үйлчилгээний нэгж болон үндсэн нэгжийн хоорондын ажлын уялдаа хамаарлаас шалтгаалан цахим үйлчилгээний төрөл, хэлбэрийн тасралтгүй, шуурхай байдал хязгаарлагдмал байна.

2.2.3. Шударга ёсыг тогтоох, авлигыг бууруулах чиглэлээр:

2.2.3.1. хуулиар нийтийн албан тушаалтан хөрөнгө орлого, ашиг сонирхлоо мэдүүлдэг болсон нь авлигаас урьдчилан сэргийлэх, нийтийн албыг тунгалаг байлгахад чиглэсэн чухал алхам хэдий ч мэдүүлгийг үнэн зөв гаргасан эсэхэд тавих хяналт сул байна. Хөрөнгө орлогын мэдүүлгийг олон нийтэд нээлттэй байлгахаар хуульчилсан ч иргэд энэ талаар мэддэггүй, мөн төрийн өндөр, дээд албан тушаалтуудын мэдүүлгээс бусад мэдүүлэгтэй танилцах боломж хязгаарлагдмал байна;

2.2.3.2. батлагдсан эрх зүйн актуудыг бүрэн эхээр нь олж үзэх боломж иргэн бүрт, тэр дундаа алслагдсан орон нутгийн иргэдэд хүртээмжтэй бус байна;

2.2.3.3. хууль, шүүхийн байгууллагын үйл ажиллагааг боловсронгуй болгох, институтийн хувьд чадавхийг нь бэхжүүлэх, хариуцлагатай, ил тод байдлыг нэмэгдүүлэх хүрээнд багц хуулиудыг батлан мөрдүүлж байгаа ч иргэд эдгээр шинэчлэл, өөрчлөлтийн талаар хангалттай мэдээлэлгүй хэвээр байна.

Гурав. Нээлттэй Засгийн түншлэлийн үйл ажиллагааны зарчим ба хүрээ

3.1. Үйл ажиллагааны зарчим:

3.1.1. *сайн туршлагад тулгуурлах-иргэдийн зүгээс санал, гомдол ихээр ирж байгаа төрийн ажил, үйлчилгээг сонгон авч богино хугацаанд үр дүн гаргах бөгөөд сайн туршлагаа үндэсний хэмжээнд түгээн дэлгэрүүлэх арга замаар ажиллах;*

3.1.2. *мэдээлэл, технологийн дэвшлийг нэвтрүүлэх-мэдээлэл, технологи, харилцаа холбооны давуу талыг ашиглан цаг хугацаа, орон зайнаас үл хамааран мэдээлэл, үйлчилгээг хурдан шуурхай иргэдэд хүргэх;*

3.1.3. *хамтын үйл ажиллагааг хангах-Нээлттэй Засгийн санаачилгыг төр ба иргэний нийгмийн байгууллагын зөвшилцөл, хамтын үйл ажиллагаагаар хэрэгжүүлэх ба оролцогч талуудыг байнга сэдэлжүүлж, үр дүнгээ үнэлэн, иргэдэд эргэн тайлагнаж байх;*

3.1.4. *улс төрийн манлайлал, үндэсний удирдлагыг бүрдүүлэх-Нээлттэй засгийн түншлэлийн үндэсний төлөвлөгөөг хариуцан ажиллах Үндэсний хороог байгуулж, хэрэгжүүлэх бүтцийг Засгийн газарт бүрдүүлэн, санхүүжилтийг шийдвэрлэн, улс төрчдийн манлайллаар хангах.*

3.2. Үйл ажиллагааны хүрээ:

Монгол Улсын Засгийн газраас Нээлттэй Засгийн түншлэлийн хүрээнд дараах үндсэн турван чиглэлээр ажиллана:

3.2.1. төрийн ил тод байдлыг нэмэгдүүлэх;

3.2.2. төрийн үйлчилгээг сайжруулах;

3.2.3. шударга ёсыг бэхжүүлж, авлигыг бууруулах зэрэг болно.

3.3. Үйл ажиллагааны үндэсний төлөвлөгөөг боловсруулсан үйл явцын танилцуулга:

3.3.1 Монгол Улсын Нээлттэй засгийн түншлэлийн үйл ажиллагааны үндэсний төлөвлөгөө боловсруулах төр ба төрийн бус байгууллагын төлөөллийн бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулагдсан³. (2013 оны 7 сар)

³ Монгол Улсын Ерөнхий сайдын 2013 оны 107 дугаар захирамж

3.3.2 Нээлттэй Засгийн түншлэлийн үйл ажиллагааны төлөвлөгөөг төр, төрийн бус байгууллагын төлөөлөлтэй биечлэн хэлэлцүүлж, орон нутгийн ИТХ ба ЗДТГ-ын ажилтнуудын дунд цахим хэлбэрээр зохион байгуулж, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр шууд нэвтрүүлсэн болно. (2013 оны 8 сар)

3.3.3 Хэлэлцүүлгийн саналд үндэслэн Нээлттэй Засгийн түншлэлийн үндэсний төлөвлөгөөг боловсронгуй болгож, үндэсний хэмжээнд санал авахаар зохион байгуулсан. Үүнд: Яамдаас бичгээр болон төрийн бус байгууллага ба иргэдээс цахим санал хүлээн авсан. (2013 оны 8 сар)

3.3.4 Нээлттэй Засгийн түншлэлийн үндэсний төлөвлөгөөний төслийг Засгийн газрын хуралдаанд танилцуулсан. (2013 оны 11 сар 12)

3.3.5 Нээлттэй Засгийн түншлэлийн цахим хуудас ажиллуулах зэрэг болно. (2013 оны 12 сар)

3.4 Нээлттэй Засгийн түншлэлийн ба үндэсний төлөвлөгөөг хэрэгжүүлэх бүтэц, зохион байгуулалт:

3.4.1 Нээлттэй засгийн түншлэлийн үйл ажиллагааны үндэсний төлөвлөгөөний хэрэгжилтэд бодлогын дэмжлэг үзүүлэх Үндэсний зөвлөл байгуулна.

3.4.2 Үндэсний зөвлөлийн дэргэд үндэсний төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих хөндлөнгийн тогтолцоог бүрдүүлнэ.

3.4.3 Үндэсний төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлын хүрээнд төрийн төв ба орон нутгийн захиргааны байгууллагын удирдлагуудтай харилцан ойлголцох санамж бичиг боловсруулж, гарын үсэг зурж баталгаажуулна.

3.4.4 Засгийн Газрын Хэрэг эрхлэх газарт Нээлттэй Засгийн түншлэлийн ажлын албыг байгуулна.

Дөрөв. Үйл ажиллагааны үндэсний төлөвлөгөө

Нээлттэй Засгийн түншлэлийн хүрээнд дараах үйл ажиллагааны үндэсний төлөвлөгөөг хэрэгжүүлнэ:

(Нээлттэй засгийн түншлэлийн үйл ажиллагааны үндэсний төлөвлөгөөг харна уу. Цаашид үндэсний төлөвлөгөө гэх)